



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 09/54

Булган

Хайгуулын болон ашиглалтын тусгай
зөвшөөрөл цуцлуулах санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.1, 62.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 48 дугаар зүйлийн 48.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Идрэн 4-р багийн иргэдийн саналыг хэлэлцэн тус сумын нутаг дэвсгэрт байрших “Өндөр” нэртэй 14389 гектар талбайг хамарсан XV-020883 дугаартай “Корунд гео” ХХК-д олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрөл, “Улаан” нэртэй 1274.4 гектар талбайг хамарсан XV-016057 дугаартай “Лидер эксплорейшн” ХХК-д олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрөл, “Хуурай тал” нэртэй 9348 гектар талбайг хамарсан MV-021963 дугаартай “Алтаргана хайрхан” ХХК-д олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрөл, “Нуур” нэртэй 1701.80 гектар талбайг хамарсан XV-021396 дугаартай “МШҮБ МАЙНИНГ” ХХК-д олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрөл, “Довжоот” нэртэй 1393.37 гектар талбайг хамарсан хайгуулын тусгай зөвшөөрлийн лицензүүд, “Алтан нар” нэртэй 3809 гектар талбайг хамарсан XV-014726 дугаартай “Эрдэнэ Монгол” ХХК-д олгогдсон ашиглалтын тусгай зөвшөөрөл, “Аман гол” нэртэй 6535 гектар талбайг хамарсан XV-010351 дугаартай “Эпидот” ХХК-д олгогдсон ашиглалтын тусгай зөвшөөрөл, “Хул морьт” ХХК-д олгогдсон “Улаан толгой” нэртэй 1658 гектар талбайг хамарсан XV-007337 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл, “Хул морьт” нэртэй 990 гектар талбайг хамарсан XV-007334 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл, “Баян хар уул” нэртэй 1574 гектар талбайг хамарсан XV-010312 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл, “Хул морьт-1” нэртэй 309 гектар талбайг хамарсан XV-014843 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар тус тус хэлэлцээд цуцлуулах саналыг дэмжсүгэй.

2. Сумын нийт газар нутгийн 66.6 хувь нь Говийн их дархан цаазат газарт хамаардаг, ард иргэдэд бэлчээр, усны хомсдол нүүрлэх, ан амьтад ангаж хатах, заган ой устгах, байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдах аюулд орж байгаа тул малчид,